

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2024/20/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn  
Ахлах аудитор Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn  
Аудитор: С.Гансүх  
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn  
Аудитор: Д.Отгонбаяр  
Утас: 99508088 Цахим хаяг: Dotgoo467@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт****ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Б.БАТХҮҮ ТАНАА

2024.03.15 № 01/264  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хараат бус аудиторын дүгнэлт****Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Могойн гол ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Могойн гол ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

"Могойн гол ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийхэд материаллаг боловч өргөн тархаагүй дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Могойн гол ХК нь тайлант онд хөрс хуулалтын ажлыг 50 хувь, олборлох нүүрсний хэмжээг 64.0 хувь, борлуулах нүүрсний хэмжээг 41.4 хувиар дутуу биелүүлсэн ба нийт ашгийн зорилтот түвшнийг 621.2 сая төгрөгөөр хангаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Захирал дараах эрх, үүрэгтэй: ... 3/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах ..." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.
2. Гүйцэтгэх захирал нь Таван хаан коул ХХК-тай 2022 оны 7 дугаар сарын 02-ны өдөр НБҮ-01-02 дугаартай "Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг лизингийн хэлбэрээр ашиглах тухай" гэрээг байгуулсан ба гүйцэтгэгч тал үйлдвэрийг угсарч хүлээлгэж өгөөгүй, цаашид энэ үйлдвэр нь компанид ямар хэмжээний үр ашиг өгөх нь тодорхойгүй байхад 221.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн нь компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй" Энэ хуулийн 84.4.3 "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" заалтыг хангахгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн 174.8 га талбай бүхий 2,796.5 сая төгрөгийн үнэлгээтэй газар эзэмших/ашиглах 2 эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгээгүй нь НББОУС 38.21 *“Биет бус хөрөнгийн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө: Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж тухайн байгууллагад орох магадлалтай; мөн хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой”* дахь заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөнд заасан гадаад аяллын зардлыг 0.1 сая төгрөг, дотоод аяллын зардлыг 17.7 сая төгрөг, ажилчдын сувиллын зардлыг 7.5 сая төгрөгөөр, нийт 25.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан байна. Дээрх зөрчлөөс харахад гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж үзлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т *“Захирал дараах эрх, үүрэгтэй: ... 3/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах ...”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Могойн гол ХК-ийн эргэлтийн хөрөнгө 9,467.2 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 5,948.2 сая төгрөг болж, төлбөрийн чадварыг өмнөх онтой харьцуулахад 3.6 дахин буурч, санхүүгийн үйл ажиллагаанд сөрөг үр дагавруудыг бий болгосон нь тасралтгүй үйл ажиллагаа явуулахад нөлөөлж болзошгүй байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай 830.8 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, бизнес төлөвлөгөө, зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй, дотоод хяналт хангалтгүй байгаа зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Төлөөлөн удирдах зөвлөлөөс Могойн гол ХК-ийн бизнес төлөвлөгөөг батлахдаа авлага, өглөгийн дээд хязгаарыг батлаагүй, компанийн санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, их хэмжээний дүнтэй гэрээ хэлэлцээрт хяналт хэрэгжүүлээгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	455,965,933.98	100,475,164.05
1.1.02	Дансны авлага	85,538,927.42	401,285,037.30
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	16,539,696.59	107,695,024.62
1.1.04	Бусад авлага	3,098,709.17	4,390,437.50
1.1.06	Бараа материал	4,421,432,561.89	8,216,479,339.72
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	382,597,400.00	625,185,313.61
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	26,511,264.78	11,709,156.12
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,391,684,493.83</b>	<b>9,467,219,472.92</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,377,386,614.89	1,966,201,857.60
1.2.02	Биет бус хөрөнгө	225,284,475.76	189,648,221.20
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,602,671,090.65</b>	<b>2,155,850,078.80</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,994,355,584.48</b>	<b>11,623,069,551.72</b>
2.1.1.01	Дансны өглөг	72,639,046.33	2,151,932,301.17
2.1.1.03	Татварын өр	45,499,054.77	618,539,846.32
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0	62,976,414.03
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	794,453,452.25	3,073,452,696.75
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	28,070,000.00	41,329,750.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	940,661,553.35	5,948,231,008.27
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	793,230,990.80	789,830,990.80
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	793,230,990.80	789,830,990.80
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,733,892,544.15</b>	<b>6,738,061,999.07</b>
2.3.01	Өмч: - төрийн	42,310,722.00	42,310,722.00
2.3.02	- хувийн	40,651,478.00	40,651,478.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,375,789,181.23	1,375,789,181.23
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	202,833,326.81	202,833,326.81
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>3,598,878,332.29</b>	<b>3,223,422,844.61</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0	665,157,716.32
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	3,598,878,332.29	2,558,265,128.29
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,260,463,040.33</b>	<b>4,885,007,552.65</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,994,355,584.48</b>	<b>11,623,069,551.72</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	6,987,983,289.16	8,794,754,560.49
02	Борлуулалтын өртөг	4,452,785,460.06	5,808,585,091.14
03	Нийт ашиг( алдагдал)	2,535,197,829.10	2,986,169,469.35
08	Бусад орлого	57,113,480.50	56,240,141.82
08.1	Орлогын дүн	57,113,480.50	56,240,141.82
09	Борлуулалт, маркетингийн зардал	433,220,280.48	812,430,115.75
10	Ерөнхий ба удирдлагын зардал	551,033,040.52	906,438,804.32
12	Бусад зардал	248,331,200.63	527,724,892.59
12.1	Зардлын дүн	1,232,584,521.63	2,246,593,812.66

13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8,157.50	0.00
17.1	Олз, гарзын дүн	8,157.50	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	1,359,734,945.47	795,815,798.51
19	Орлогын татварын зардал	142,555,414.55	130,658,082.19
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,217,179,530.92	665,157,716.32
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	1,217,179,530.92	665,157,716.32

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөг

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>82,962,200.00</b>	<b>1,375,789,181.23</b>	<b>202,833,326.81</b>	<b>2,904,069,868.37</b>	<b>4,565,654,576.41</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	1,217,179,530.92	1,217,179,530.92
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-522,371,067.00	-522,371,067.00
<b>2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>82,962,200.00</b>	<b>1,375,789,181.23</b>	<b>202,833,326.81</b>	<b>3,598,878,332.29</b>	<b>5,260,463,040.33</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	665,157,716.32	665,157,716.32
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-1,040,613,204.00	-1,040,613,204.00
<b>2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>82,962,200.00</b>	<b>1,375,789,181.23</b>	<b>202,833,326.81</b>	<b>3,223,422,844.61</b>	<b>4,885,007,552.65</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,587,253,493.23	11,566,369,559.34
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,477,653,699.98	11,456,216,704.05
1.1.6	Бусад мөнгөн орлого	109,599,793.25	110,152,855.29
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,260,981,041.16	10,156,084,753.97
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,229,014,385.00	1,979,572,383.01
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	378,572,988.30	543,824,218.86
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,466,584,103.06	1,319,514,032.46
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	89,912,100.55	134,451,105.41
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,085,833,298.06	3,175,725,467.94
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,354,170,175.81	489,702,559.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	19,848,263.72	26,694,775.37
1.2.9	Бусад мөнгөн зарлага	637,045,726.66	2,486,600,211.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	326,272,452.07	1,410,284,805.37
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	426,154,550.00	817,029,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	375,624,970.00	817,029,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,529,580.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-426,154,550.00	-817,029,800.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	477,313,242.00	948,745,775.30
3.2.4	Төлсөн ногдол ашиг	477,313,242.00	948,745,775.30
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-477,313,242.00	-948,745,775.30
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-577,195,339.93	-355,490,769.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	146,272,287.03	455,965,933.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	455,965,933.98	100,475,164.05

## 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн	Хувь
1	Урд оноос шилжсэн нүүрс	мян.тн	95.0	96.0	1.0	101.1
2	Хөрс хуулалт/мян.м3/	мян.тн	2,500.0	1,249.9	(1,250.1)	50.0
3	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	90.0	(160.0)	36.0
4	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	250.0	146.6	(103.4)	58.6
<b>5</b>	<b>Нийт орлого</b>	<b>мян.төг</b>	<b>18,314,000.0</b>	<b>8,850,994.7</b>	<b>(9,463,005.3)</b>	<b>48.3</b>
6	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	18,250,000.0	8,557,943.8	(9,692,056.2)	46.9
7	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	20,000.0	187,115.4	167,115.4	935.6
8	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг		62,333.6	62,333.6	
9	Халаалтын орлого	мян.төг	44,000.0	43,601.9	(398.1)	99.1
<b>10</b>	<b>Нийт зардал</b>	<b>мян.төг</b>	<b>16,897,062.2</b>	<b>8,055,178.9</b>	<b>(8,841,883.3)</b>	<b>47.7</b>
11	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	14,190,504.5	5,463,669.6	(8,726,834.9)	38.5
12	Бараа материал борлуулсны өртөг	мян.төг	15,000.0	140,252.9	125,252.9	935.0
13	Уурын зуухны зардал	мян.төг	152,478.4	155,900.1	3,421.7	102.2
14	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	67,481.8	48,762.4	(18,719.4)	72.3
15	Удирдлагын зардал	мян.төг	1,107,556.1	906,438.8	(201,117.3)	81.8
16	Борлуулалтын ажиллагааны зардал	мян.төг	1,032,141.4	812,430.1	(219,711.3)	78.7
17	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	331,900.0	527,725.0	195,825.0	159.0
<b>18</b>	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>мян.төг</b>	<b>1,416,937.8</b>	<b>795,815.8</b>	<b>(621,122.0)</b>	<b>56.2</b>
19	Орлогын албан татвар	мян.төг	141,693.8	130,658.1	(11,035.7)	92.2
20	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,275,244.0	665,157.7	(610,086.3)	52.2

**Гурав. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 830.8 сая төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 830.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

***Залруулсан алдаа:***

1. Туасиа ХХК-аас түрээсэлсэн техникүүдийн түрээсийн урьдчилж гарсан зардлыг 337.4 сая төгрөг гэж бүртгэснийг хянаж үзэхэд 62.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Урьдчилж төлсөн зардал дансыг 62.0 сая төгрөгөөр бууруулж, дуусаагүй үйлдвэрлэл дансыг 62.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх залруулга хийлээ.

2. Хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн Эмералд энд спаркле ХХК-тай санхүүгийн тайлан гарсны дараа гэрээ дүгнэж тооцоо хийхэд үлдэгдэл 768.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө, 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:..14.4. 2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заалттай нийцэхгүй ба “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Дутуу төлсөн 768.9 төгрөгийг дансны өглөг, дуусаагүй үйлдвэрлэл дансыг нэмэгдүүлэх залруулга хийлээ.

Аудитаар нийт 3,664.0 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 646.5 сая төгрөгийн 1 зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 221.0 сая төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 2,796.5 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

***Хариуцлага тооцох албан шаардлага:***

- Могойн гол ХК нь тайлант онд хөрс хуулалтын 2,500.0 мянган м3 ажлын төлөвлөгөөг 50 хувиар дутуу биелүүлж 1249.9 мянган м3 хөрс хуулалт хийж, олборлох нүүрсний хэмжээг 64.0 хувиар дутуу биелүүлж, борлуулах нүүрсний хэмжээг 103.4 мянган тонноор дутуу биелүүлсэн байна. Үүнээс шалтгаалан Гүйцэтгэлээр орлогыг 9,463.0 сая төгрөг буюу 51.7 %-аар дутуу биелүүлж, нийт зардлыг 8,841.9 сая төгрөг буюу 47.7 %-ийн гүйцэтгэлтэй, 795.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, нийт ашгийн зорилтот түвшнийг 621,1 сая төгрөгөөр хангаагүй байна. Мөн Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг батлахдаа гадаад аяллын зардал 85.0 сая төгрөг, дотоодын аяллын зардал 75.0 сая төгрөг, ажилчдын сувиллын зардал 15.0 сая төгрөг нийт 175.0 сая төгрөгийг баталсан боловч гадаад аяллын зардлыг 0.14 сая төгрөг, дотоод аяллын зардлыг 17.7 сая төгрөг, ажилчдын сувиллын зардлыг 7.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1 “Захирал дараахь эрх, үүрэгтэй: ...3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах...” заалт, Могойн гол ХК-ийн 2023 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөтэй нийцэхгүй байгаа тул гүйцэтгэх захиралд хариуцлага тооцох албан шаардлагыг ТУЗ-д өгөхөөр шийдвэрлэлээ.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

**1.2 Албан шаардлага**

Таванхаан коул ХХК-тай “Нүүрс баяжуулах чиглэлээр хамтран ажиллах тухай” санамж бичгийг 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулан хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг нийлүүлэхээр тохиролцсон байна. Санамж бичгийн дагуу 2022 оны 7 дугаар сарын 02-ны өдөр НБҮ-01-02 дугаартай “Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг лизингийн хэлбэрээр ашиглах тухай” гэрээг байгуулан 2 жилийн хугацаанд 665.0 сая төгрөгийг сар бүр 26-28 сая төгрөг төлөхөөр байгуулж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 221.0 сая төгрөг төлсөн байна. Үйлдвэрийг одоо болтол угсарч хүлээлгэж өгөөгүй, цаашид энэ үйлдвэр нь компанид ямар хэмжээний үр ашиг өгөх нь тодорхойгүй байна. Энэ нь компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:84.4.3.компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” заалтыг баримталж ажиллаагүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Төлөөлөн удирдах зөвлөлд:**

##### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тайлант онд хөрс хуулалтын ажлыг хугацаанд нь зохион байгуулж ажиллаж чадаагүйгээс өмнөх онтой харьцуулбал урьдчилж орсон орлого 2,279.0 сая төгрөг, дансны өглөг 2,079.3 сая төгрөг, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өглөг 636.0 сая төгрөг, бусад богино хугацаат өр 13.3 сая төгрөг нийт 5,007.6 сая төгрөгөөр богино хугацаат өр өссөн байна. Мөн авлага 408.2 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал 579.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь компанийн төлбөрийн чадварыг эрс бууруулсан үзүүлэлт болоод байна. Тухайлбал эргэлтийн харьцаа 2022 онд 5.7 байсан бол 2023 онд 1.7 болж 3.4 дахин буурсан байна. Өөрөөр хэлбэл богино хугацааны төлбөрийн чадвар ийм хэмжээгээр буурсан нь удирдлагын хяналт алдагдсантай холбоотой гэж үзэж байна. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 81.4, 79.4 дэх заалттай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

ТУЗ-аас компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, их хэмжээний хэлцэл, худалдан авах ажиллагаанд хяналт тавих үүргээ биелүүлж ажиллах, ТУЗ-аас эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа компанийн өглөг, авлагын дээд хязгаарыг зохистой түвшинд тогтоож байх

##### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Завсрын аудитаар Могойн гол ХК нь Центр ХХК-тай байгуулсан гэрээний дагуу томилолтоор явсан компанийн удирдлагуудын буудлын 1 хоногийн төлбөрийг 350,000 төгрөгөөр хэт өндөр тооцож, зочид буудалд олон хоногоор байрласан зөрчилд аудитын явцад компанид учирсан 9.2 сая төгрөгийн хохирлыг буруутай этгээдээр компанийн дансанд төлүүлсэн. Дээрх зөрчил нь томилолтын зардлын тарифыг ТУЗ-өөс батлаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтын зардлын тарифыг хэмнэлттэй байдлаар тогтоож батлах

#### **Гүйцэтгэх удирдлагад:**

##### **3. Балансын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн 174.78 га талбай бүхий 2,796.5 сая төгрөгийн үнэлгээтэй газар эзэмших/ашиглах 2 эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгээгүй байна. Энэ нь: Газрын ерөнхий хуулийн 67.1. Дараах эрх бүхий байгууллага, албан тушаалтан дор дурдсан үндэслэлээр газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргана: 67.1.1 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд газрыг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, газар ашиглах хүсэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага", Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.3.эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" ...гэсэн заалттай нийцэхгүй ба "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Газар ашиглах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж, санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэх

##### **4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Хөрс хуулах ажил гүйцэтгэх тендер зарлаж, техникийн түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй Туасиа ХХК-тай 2023 оны 11 сарын 15-нд 2.3 тэрбум төгрөгийн хөрс хуулах гэрээ байгуулсан. Туасиа ХХК 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 2 дугаар сард багтаан 400,000 м.куб хөрс хуулах байсан боловч тохиромжгүй хугацааг сонгон гэрээнд тусгаснаас гэрээний хугацаанд ажил хийгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээ хэлэлцээрийг хийхдээ биелэх боломжит цаг хугацаа, нөхцөлийг тусгаж байх

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Туасиа ХХК-аас түрээсэлсэн техникүүдийн түрээсийн урьдчилж гарсан зардлыг 337.4 сая төгрөг гэж бүртгэснийг хянаж үзэхэд 62.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	1	61,975.0			1	61,975.0	1	61,975.0				
Хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн Эмералд энд спаркле ХХК-тай санхүүгийн тайлан гарсны дараа гэрээ дүгнэж тооцоо хийхэд үлдэгдэл 768.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй байна	1	768,861.2	1	768,861.2			1	768,861.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>830,836.2</b>	<b>1</b>	<b>768,861.2</b>	<b>1</b>	<b>61,975.0</b>	<b>2</b>	<b>830,836.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй	1	646,509.7							1	646,509.7
Таванхаан коул ХХК нүүрс баяжуулах үйлдвэрийг одоо болтол угсарч хүлээлгэж өгөөгүй	1	221,000.0			1	221,000.0				

байхад 221.1 сая төгрөгийг төлсөн байна									
Ашиглалт, олборлолт явуулж буй уурхайн 174.78 га талбай бүхий 2,796.5 сая төгрөгийн үнэлгээтэй газар эзэмших/ашиглах 2 эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгээгүй байна.	1	2,796,480.0					1	2,796,480.0	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,663,989.7</b>			<b>1</b>	<b>221,000.0</b>	<b>1</b>	<b>2,796,480.0</b>	<b>1</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Томилолтын зардлын тарифыг ТУЗ-өөс батлаагүй	1						1	
ТУЗ-аас эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа авлага, өглөгийн дээд хязгаарыг батлаагүй	1						1	
Туасиа ХХК-тай 2023 оны 11 сарын 15-нд 2.3 тэрбум төгрөгийн хөрс хуулах ажил гэрээний хугацаанд хийгдээгүй байна.	1						1	
Дүн	3						3	
<b>Нийт дүн</b>	<b>3</b>						<b>3</b>	